

Увс аймгийн хил орчмын зэрлэг амьтны ажиглалт, судалгааны мэдээ

Хилийн цэргийн албаны гол үүргийн нэг нь тухайн хил орчмын газрын төлөв байдал, хотгор гүдгэрийн онцлог, бартаа саад, хил хамгаалахад учирч болох бэрхшээл гэх мэт байгалийн байдлыг ажиглан судлах, тэдгээр онцлогийг мэдэх явдал байдаг.

Хил хамгааллын ажиллагаа улирал, сараар төдийгүй хоногоор солигдон өөрчлөгдөх цаг уурын нөхцөлтэй зохицон уялдаж байдаг. Хил зөрчигчид цаг уурын тааламжгүй нөхцөл байдал, шөнийн харанхуйг далимдуулах магадлалтай байдаг. Иймээс цас орвол хаана их хунгарлах, хаагуур явж болох, бороо орвол хаана хоргодон бүгж болох, үер буувал хаагуур ямар аюул учруулах, хаагуур хүчтэй салхилах, салхи ихтэй үед хаана нөмөр нөөлөгтэй гэх мэт олон зүйлийг мэдэж байх шаардлага гарах нь дамжиггүй.

Үүний зэрэгцээ нутгийнхаа байгалийн баялгийн төлөв байдлыг ч бас анхааран судлах шаардлагатай болно. Хаанаас ус олдох, авах, ямар амьтан хаагуур бэлчээрлэдэг, хичнээн тоо толгойтой байдаг, байнга суурьшмал байдаг уу, эсвэл нүүж орж ирэв үү гэх мэт асуудлыг мэдэж байх нь хэрэг зөрчлийг мөрдөж мөшгих, илрүүлэхэд тус дэмтэй.

Байгаль хамгааллын салбарынхан хилчдийн энэхүү онцлогийг харгалзан хил орчмын байгаль хамгаалах ажилд хамтран ажиллах сонирхолтой байдаг бөгөөд ийм туршлага ч багагүй бий. Үүний жишээ нь Монголын зүүн хил орчимд голлон хэрэгжсэн “Монголын биологийн төрөл зүйл”, “Дорнод монголын биологийн төрөл зүйлийн төсөл” ба хил хамгааллын албаныхны хамтын ажиллагаа юм.

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)- гийн Монгол дахь хөтөлбөрийн газрын хамт олон бид ч энэ талаар багагүй чармайлт гаргадаг ба энэ удаад хилчдээс хил орчмын аргаль хонины шилжилт хөдөлгөөн, нүүдэл, тоо толгой, сүргийн бүтцийн асуудалд анхаарлаа хандуулахыг хүсч байна. Аргаль хонь нь Монгол, Оросын хил дамнан нүүдэллэдэг тул түүнийг ажиглаж байх нь хил хамгаалалд ч тус дэм болно гэж үзэж байна. Уг амьтан нь их сонор соргог тул түүний хөдөлгөөн, шилжилтийг ажигласнаар хил хамгаалалтай холбоотой хэрэг зөрчил илрүүлэхэд тусалж ч болох юм.

Энэ зорилгын үүднээс хамгийн энгийн, хөтлөхөд хялбар хүснэгт хийж мэдээлэл авч байхыг зорьсон болно. Хэдийгээр хялбаршуулан энгийн болгосон ч гэсэн мэдээллийг үнэн бодитоор цуглуулсан л бол энэ нь аргаль хонь хамгааллын менежментэд чухал ач холбогдолтой гэдгийг онцгойлон хэлэх нь зүйтэй. Яагаад гэвэл тэр амьтны амьдралыг жилийн дөрвөн улирлын туршид ажиглах боломж судлаачдад тэр бүр олддоггүй. Иймээс аргаль хонь хэдийд хаагуур байршдаг, ямар бэлчээрт голлон идээшлэдэг, эзэмшил нутаг нь хир том талбайтай, сүргийн бүтэц, сүрэглэлийн байдал, тоо толгойд нөлөөлж буй хүчин зүйлс зэргийг мэдэх боломжтой бөгөөд улмаар хамгаалахын тулд хаана, ямар ажил зохиох хэрэгтэй вэ?, түүнийг яаж төлөвлөн хэрэгжүүлэх вэ? гэх мэт асуудалд хариу өгөх боломжтой юм. Иймд уг мэдээнд байгаль хамгааллын биологичид их ач холбогдол өгч байгааг болгоон соёрхоно уу.

Увс аймгийн хилийн 1,2-р заставын хариуцсан хэсгийн ан, амьтны мэдээ

Аргаль хонины шилжилт хөдөлгөөний судалгааг Увс аймгийн хилийн 1,2-р заставуудтай 2007 оны 6-р сараас эхлэн хамтран ажиглалт судалгааг хийж байгаа. Увс аймгийн Хилийн 1,2-р заставын 2007 оны 8-р сараас эхлэн хил орчимд тэмдэглэгдсэн аргаль хонины мэдээг эмхэтгэв.

Хилийн 1-р застав хэсэгт

Сүрэглэл, сүргийн бүтэц

Сүрэгтээ 1-5 бодгальтай сүрэг 4 (энэ нь нийт сүргийн 40,0%) байсан ба үүнд 12 аргаль хонь (энэ нь нийт аргаль хонины 11,1%), 6-10 бодгальтай сүрэг 3 (энэ нь нийт сүргийн 30,0%) байсан ба үүнд 27 аргаль хонь (энэ нь нийт аргаль хонины 25,0%), 11-15 бодгальтай сүрэг 1 (энэ нь нийт сүргийн 10,0%) байсан ба үүнд 13 аргаль хонь (энэ нь нийт аргаль хонины 12,0%), 16-20 бодгальтай сүрэг 1 (энэ нь нийт сүргийн 10,0%) байсан ба үүнд 16 аргаль хонь (энэ нь нийт аргаль хонины 14,8%), 41-50 бодгальтай сүрэг 1 (энэ нь нийт сүргийн 10,0%) байсан ба үүнд 40 аргаль хонь (энэ нь нийт аргаль хонины 37,0%) тус тус байсан байна.

Сүргийн бүтэц нь угалз: хомь: төлөг гэсэн дарааллаар 0.9%: 5.6%: 1.9% байлаа. 1-р застав орчимд хурга хараагүй буюу аль эсвэл хурга, төлөг хоёрыг адуурч ангилсан байх.

Хомь, угалзын харьцаа 100:16.6, хомь, төлөгний харьцаа 100:33.3 байна. 1-р застав орчимд 2008 оны 2-р сарын 21 өдөр 9 тооны янгир ямаа харагдсан байна.

2007 оны 11-р сарын 29 өглөөний 9 цагийн үед ОХУ-ын талаас 40 аргаль хилийн тор таслан орж ирсэн гэсэн байна. Аргаль хонь тор таслан орж ирэх гарах зэрэг мэдээлэлийг маш сайн баримтжуулж солбилцол болон зурга авж байх шаардлагтай байна.

Хилийн 2-р застав хэсэгт

Сүрэглэл, сүргийн бүтэц

Сүрэгтээ 1-5 бодгальтай сүрэг 4 (энэ нь нийт сүргийн 33,3%) байсан ба үүнд 16 аргаль хонь (энэ нь нийт аргаль хонины 8,2%), 6-10 бодгальтай сүрэг 2 (энэ нь нийт сүргийн 16,7%) байсан ба үүнд 14 аргаль хонь (энэ нь нийт аргаль хонины 7,1%), 11-15 бодгальтай сүрэг 1 (энэ нь нийт сүргийн 8,3%) байсан ба үүнд 12 аргаль хонь (энэ нь нийт аргаль хонины 6,1%), 16-20 бодгальтай сүрэг 3 (энэ нь нийт сүргийн 25,0%) байсан ба үүнд 51 аргаль хонь (энэ нь нийт аргаль хонины 26,0%), 41-50 бодгальтай сүрэг 1 (энэ нь нийт сүргийн 8,3%) байсан ба үүнд 43 аргаль хонь (энэ нь нийт аргаль хонины 21,9%), 51 дээш бодгальтай сүрэг 1 (энэ нь нийт сүргийн 8,3%) байсан ба үүнд 60 аргаль хонь (энэ нь нийт аргаль хонины 30,6%) тус тус байсан байна.


Сүргийн бүтэц нь угалз: хомь: төлөг: хурга гэсэн дарааллаар 20.4%: 16.8%: 13.3%: 8.2% байлаа.

Хомь, төлөгний харьцаа 100:78.7, хомь, хурганы харьцаа 100:48.4 байна. Өөрөөр хэлбэл популяцийн нөхөн төлжлийн хувь нь 78.7% байхад төллөлтийн хувь нь 49,4% байна.

Хилийн 2-р заставын хэсэгт янгир ямаа болон буга байдаг байна. 5 сүрэг 38 бодгаль янгир ямаа бүртэгсэнээс 2 сүрэг 19 бодгалийн нас хүйсийг тодорхойлсоноос 9 тэх, 6 эмгэж, 2 борлон, 2 ишиг байсан байна. 2008 оны 1-р

сарын 25, 29-ний өдөрүүдэд 9 бодгаль мөн 14 бодгаль бүхий 2 сүрэг буга харсан байна.

Увс аймгийн хил орчмын зэрлэг амьтны ажиглалт, судалгааны дүнгийн нэгтгэл



Тайлбар

- | | | | | | |
|-------------------------------------|---------------------|--------------|--|-------------------------------------|--------------------|
| | 1 | Аргаль | | 1 | Хилийн топ |
| | 2 | Янгир | | <input checked="" type="checkbox"/> | boundary_country |
| | 3 | Буга | | <input checked="" type="checkbox"/> | boundary_soums |
| <input checked="" type="checkbox"/> | point | | | <input checked="" type="checkbox"/> | local_pa_071231mng |
| | <call other values> | | | <input checked="" type="checkbox"/> | protect_areas_last |
| | 1 | Заставын төв | | | |
| | 2 | Харуул | | | |
| | 5 | Түр харуул | | | |
| | 8 | Ажиглах цэг | | | |

Ажиглалтыг яаж хийх вэ?

Хил хамгаалагч та бүхэн өнөөдөр тэнд өчнөөн угалз (эр аргаль) байна, өчигдөр нэг хургатай хомь (эм аргаль) тааралдсан, энэ сүрэг дотор өчнөөн төлөг, төчнөөн хурга байна гэж хоорондоо ярьж, мэдээлэл дамжуулдаг болчихвол том амжилтад хүрлээ гэсэн үг. Бид та нарыг ийм ажилд суралцуулж чадвал бас сайхан амжилт. Хил хамгаалагч та нар, байгаль хамгаалагч бид үүнийг хийж чаддаг, ийм мэдээлэлд тулгуурлан ажилладаг болж чадвал бидний хамтын ажлын үр дүн гарах юм. Хил хамгаалагч нарыгаа ийм дадал заншилтай болгохын тулд бид тусалж дэмжих ажил хийнэ гэдгийг ч энэ дашрамд дурьдах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, харилцан ашигтай хамтын ажиллагаа хөгжүүлэхийг эрмэлзэж байгаа хэрэг.

Ажиглалт хийхэд юуг анхаарч, ямар дэс дарааллаар ажиллах вэ? гэдгийг дор тайлбарлах болно. Та 13 үзүүлэлттэй хүснэгтийг маш хялбар бөглөх болно. Тэр 13 нүдийг хэрхэн яаж бөглөх, түүнийг бөглөхийн тулд юунд анхаарах талаар дор бичсэн зүйлийг анхааралтай уншихыг хүсч байна. Маягт 1-ийг үзнэ үү.

I. “№” гэсэн нүдэнд ажиглалт бүрийн дугаарыг тавина. Гэхдээ “Тэмдэглэл” гэсэн XIII хэсэгт их юм бичихээр бол мөр алгасаж тэмдэглэж болох тул № гэсэн багана бүрийг дугаарлах шаардлагагүй байж болзошгүй анхаарна уу.

II. “Судалгаа хийсэн хүний овог, нэр, цол” гэсэн мөрөнд эцгийн нэрний эхний үсэг, өөрийн нэр, цэргийн цолыг бичнэ.

III. Ямар амьтан бэ? гэдгийг таньж мэдэх нь чухал. Аргаль хонь яг мөн үү, өөр амьтан биш биз гэдгийг дуран, телескопоор харж нягтална. Их холоос харсан тохиолдолд ямар амьтан байгааг тодорхойлоход хэцүү. Иймээс тааж бичиж болохгүй. Тэгээд **“Амьтны нэр”** гэсэн нүдэнд амьтнахаа нэрийг (аргаль, буга гэх мэт) бичнэ.

IV. “Огноо” гэсэн нүдэнд он, сар, өдрийг тавина. Нэг өдөр хэд хэдэн ажиглалт хийж болно гэдгийг анхаарна уу.

V. “Цаг, мин” гэсэн нүдэнд тухайн амьтныг хэдэн цаг, хэдэн минутад харснаа бичнэ. Энэ нь тэр амьтны хоногийн идэвхийн судалгаанд ач холбогдолтой гэдгийг анхаарна уу. Мөн хилээр ямар цаг, минутад гарч байгаа нь ч сонин. Иймээс судлаач цагтай байх хэрэгтэй. Хэрвээ цаггүй байсан бол цагтай хүнтэй зөвлөсний үндсэн дээр журнал дээр бичих нь зөв болов уу. Нэг өдөр хэд хэдэн газар ажиглалт хийх тул тэр нь цаг, минутаараа ялгагдана.

VI. “Заставын нэр” гэсэн нүдэнд тухайн ажиглалт аль заставын нутаг дэвсгэр дээр явагдсаныг тэмдэглэнэ. Олон застavaас мэдээ авах бөгөөд застав бүрийн “газрын код” давхцах тул төгсгөлийн шатанд нэгтгэхэд будлиан гарах тул заставын нэрийг заавал бичих шаардлагатай.

VII. “Газрын код” гэсэн нүдэнд үсэг, тооноос бүрдсэн тэмдэглэгээ буюу кодыг тавина. Жишээлбэл, А3. Та бүхэнд олгосон 1:100000-ын масштабтай (хумилттай) байр зүйн зурагт нүдийг хэвтээ тэнхлэгийн дагуу баруунаас зүүн тийш А, Б, В гэх мэтээр үсгээр дугаарласан байгаа. Харин босоо тэнхлэгийн дагуу дээрээс нь доошоо 1, 2, 3 гэх мэт тоогоор дугаарласан. Харсан аргаль хонь маань үсэг, тооны огтлолцол таарсан аль нүдэнд байгааг тогтоогоод түүнийгээ дэвтэрт бичнэ. Жишээлбэл, А3, Д2 гэх мэт. Үүнийг л код гэж нэрлэсэн хэрэг. Ингэж код бичих нь амьтан байгаа газрын байршлыг зураг дээр тэмдэглэх арга юм. Нэг сүрэг


аргаль хонь нэг биш нүдэнд тавигдаж болно. Газрын зургийн кодыг Хүснэгт 1-д үзүүлэв.

Газрын код гэсэн нүдэнд АЗ гэсэн тэмдэглэгээг илүү нарийвчилж гаргаж болох бөгөөд тийм нарийвчлалыг хилийн цэргийнхний хэрэглэдэг тэмдэглэгээгээр хийхээр тохиролцсон болно.

1:100000-ны масштабтай байр зүйн зурганд олон нүд байх бөгөөд нэг нүдний хэмжээ нь хааш хаашаагаа 2 км байдаг. Өөрөөр хэлбэл нүд бүр нь 4 км² талбайтай гэсэн үг.

VII. Аргаль хонь, эсвэл өөр амьтан хэд хичнээн тоотой байна бэ? гэдгийг тоолж тогтоогоод **“Амьтны бүх тоо”** гэсэн нүдэнд тавина. Ойролцоо өөр сүрэг байж болох тул сүрэг бүрийн доторх амьтны тоог ялган тогтоох хэрэгтэй. Анх удаа ажиглалт хийж байгаа хүмүүс харагдсан бүх амьтны тоог нэгтгэж бичээд хэдэн сүрэгт хамаарч байгааг анхааралгүй орхисноос ташаа мэдээ өгч, алдаа гаргаж болзошгүйг анхаарна уу.

Хүснэгт 1. Газрын зургийн кодыг харуулсан байдал (АЗ, Д2)



IX, X, XI, XII. Амьтныхаа бүх тоог мэдсэний дараа эр, эмийг нь тогтооно. Хэрвээ эр, эмийг нь ялгаж таньж чадахгүй бол таамаглаж бүү бичээрэй. Үүнийг тайлбарлахдаа аргаль хониор жишээ авлаа. Энэ нь аргаль хонийг хамгаалахад бид голлон анхаарч байгаатай холбоотой болно.

Аргаль хонины эр, эмийг ялгах голлох шинж нь эвэр юм. Холоос харахад угалзын хоёр эврийн угийн хооронд бараг зайгүй, нийлсэн мэт харагддаг бол хомийн эврийн угийн хооронд нилээд зайтай, эвэр нь угалзынхаас илэрхий нарийн харагддаг.

Аргаль хонины эр буюу угалз нь мушгиралдсан том эвэртэй. Үүгээрээ онцлог (Зураг 1). Угалз жилийн ихэнх хугацаанд(ороо нийлгээс бусад үед) дангаараа сүрэг үүсгэн байршдаг онцлогтойг анхаарах хэрэгтэй.

Аргаль хонины эмийг хомь гэх бөгөөд эм нь мушгиралдаж угалзраагүй, бага зэрэг нумарсан, харьцангуй нарийн, богино эвэртэй (Зураг 2). Эм бодгалиуд хоорондоо нийлж дангаараа сүрэг үүсгэнэ. Орооны үед угалзын эрүүшинд байна.

Бусад үед угалзнаас салангад байх боловч бэлчээр нутгаараа хоорондоо ойртох тохиолдол бий. Хаврын төллөлтийн үед сувай бодгалиуд дангаараа сүрэг үүсгэнэ.

Эр, эмийг нь мэдсэний дараа тэр сүргийг насаар нь ялгана. Насанд хүрсэн угалз, хомийг эхэлж мэднэ. Дараа нь энэ жил гарсан хурга байгаа, эсэхийг тогтооно (Зураг 4). Хурга нь хамгийн бага биетэй, эвэр ургасан эсэх нь бараг мэдэгдэхгүй. Гэхдээ намар орой цагийн эр хурга жижиг эвэртэй байдаг. Төгсгөлд нь төлөг байгаа эсэхийг тогтооно. Төлөг нь хурга гэхээр биеэр арай том, бие гүйцсэн гэхээр арай бага харагдана (Зураг 3).

Хялбараар ойлговол нас, хүйсээр нь аргаль хонийг “бие гүйцсэн эр”, “бие гүйцсэн эм”, “төлөг”, “хурга” гэж 4 ангилан, дэвтрийн VI, VII, VIII, IX гэсэн нүдэнд тэмдэглэнэ гэсэн үг. Ингэж ялгах нь эхний үед хүндрэлтэй байж болно. Ялгаж сурахын тулд олон удаа ажиглаж, хооронд нь харьцуулж, мэддэг туршлагатайгаасаа асууж суралцах хэрэг гарна. Олон удаагийн ажиглалтаар аандаа нүдэнд дасаад том, багаар нь ялгах чадвар сууна. Бидний зүгээс мэргэшсэн хүнээр дадлагажуулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна.

Насаар нь ялгаж танихад төвөгтэй бол тааж бичихгүй байхыг зөвлөж байна. Таамаглан бичиж, буруу ташаа мэдээ өгөх нь аргаль хонины төлөв байдлыг буруу тодорхойлох, цаашлаад шаардлагагүй хөрөнгө, хүч зарах, цаг хугацаа үрэхэд хүргэж болзошгүйг анхааруулж байна. Гэхдээ дутуу дулимаг мэдээ өгөх нь лавлах, тодруулах, давтан хийх хэрэг гарч, үр дүнд хүрэхгүйн улмаас зарцуулсан хөрөнгө, хүч, цаг маань бас л хайран болно.

XIII. “Тэмдэглэл” гэсэн нүдэнд ажигласан амьтан тайван идээшилж байлаа, үргэж цочсон байв, хилээр гарч байв, ороо хөөцөлдөөнд орж байсан, хургалж байлаа гэх мэтээр тухайн агшинд ямар төлөвтэй байсныг өөрийхөө харж, ажигласнаар бичнэ. Гэхдээ ороо нийлэг, төллөлт, хилээр зорчих гэсэн 3 асуудалд илүү анхаарах хэрэгтэй. Хилийн зурваст аргаль хонины мөр тод ажиглагдсан бол тусгайлан тэмдэглэнэ үү.



Зураг 1. Угалз. Эвэр, биеийн галбирыг ажиглана уу.



Зураг 2. Хомь. Эвэр, биеийн галбирыг ажиглана уу.

Зураг 3. Төлөг. Биеийн галбир, эврийн хэмжээ жижиг буйг ажиглана уу.



Зураг 4. Хурга



